

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чанарыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт, эмх цэгц бүхий, улс төрийн хувьд биеэ даасан, өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдлийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
 А. Нийгмийн байр суурь В. Нийгмийн тогтолцоо С. Нийгэм
 D. Нийгмийн бүтэц E. Нийгмийн харилцаа
2. Нэр хүнд ажил мэргэжлийн байр суурийн ялгарлыг нийгмийн давхраажилтын суурь шалтгаан гэж ямар эрдэмтэн үзсэн бэ? /1 оноо/
 А. Л.Уорнер В. Т.Парсонс С. Е.О.Райт D. Э.Дюркгейм E. Дэвис ба Мур
3. Нийгмийн давхраажилтын нэр хүндийн хэмжигдэхүүнд хамаарах ойлголтуудыг сонгоно уу. /2 оноо/

- | | |
|------------------------------|---|
| 1. Онцгой авьяас чадвар | 2. Олон танигдсан байдал |
| 3. Бусдад нөлөөлөх, дагуулах | 4. Нөөцийг ашиглах, хуваарилахад хяналт тавих |
| 5. Шийдвэр гаргах | 6. Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, үнэ цэн |

- А. 1, 2, 6 В. 2, 3, 4 С. 1, 3, 5 D. 1, 2, 3 E. 2, 4, 5

4. Нийгмийн давхраажилтын хэв маягуудын нэг болох “Каст”-ын тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг тодорхойлоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б	В
1-р хэсэг	Азийн орнуудын давхраажилтын уламжлалт хэв маяг	Эртний Грек, Ромд байсан	Хувийн байр сууриа өөрчлөх боломжгүй
2-р хэсэг	Шашны номлолоор хөдөлмөрийн хуваарь тогтоосон	Эндогами гэрлэлтийн хэлбэртэй	Онцгой гавьяа байгуулж, хэргэм зэрэг худалдаж авах боломжтой

- А. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – В В. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
 С. 1-р хэсэг – В; 2-р хэсэг – В D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – В
 E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

5. “Харлигууд” буюу харьяат ард иргэд дотооддоо сайн, дунд, адаг хүн гэсэн гурван хэсэгт хуваагдаж байжээ. Энэ нь монголын түүхийн аль хэсэгт хамаарах вэ? /1 оноо/
 А. Социализмын үе В. Манжийн эрхшээлийн үе
 С. Юань улсаас хойш үе D. XII-XIV зуунд E. Их Монгол улсын үед



6. Дараах ойлголтуудаас тоон судалгаанд аль нь хамаарах вэ?

/1 оноо/

1. Мэдээллийн утгыг ойлгох, дүрслэн харуулахаар зорино
2. Стандарчлагдсан загварын дагуу үр дүнг нэгтгэн бичнэ.
3. Мэдээлэл цуглуулах үйл явц нэг ижил горимоор явагдана.
4. Хэмжилт нь мэдээлэл цуглуулах явцад эсвэл дараа нь хийгдэнэ.
5. Баримт бичиг, ажиглагдсан зан үйл, үг яриа байна.

A. 2, 4

B. 2, 3

C. 1, 2

D. 1, 5

E. 3, 4

7. Дедукцийн аргын тухай дараах өгөгдлүүдийг ажиглаад зөв эрэмбэд оруулна уу. /2 оноо/

Өгөгдөл: /**a**-ажиглалт буюу мэдээлэл цуглуулах, **b**-нэгтгэн дүгнэх, **c**-онолоос асуулт, **d**-онолын хүрээний таамаглал, **e**-туршилт буюу дүн шинжилгээ/



A. 1c2a3d4b5e

B. 1c2d3a4b5e

C. 1a2c3d4b5e

D. 1a2c3d4e5b

E. 1c2d3a4e5b

8. Дараах хүснэгтэд байгаа нийгмийн хэв маягуудыг ажиглаад аль нийгмийн хэв маягийн хэд дүгээр баганад алдаа байгааг тодорхойлно уу. /2 оноо/

Нийгмийн хэв маяг	1-р багана	2-р багана	3-р багана
Ан агнуурын нийгэм	Эдүгээ Австралийн уугуул иргэд ийм төрлийн нийгмийн байгуулал бүхий байсаар байна.	Нүүдэллэн амьдардаг нийгэм бөгөөд улс төрийн бүтэц үгүй	Чулуу, сүх, жад, хутга зэрэг энгийн зэвсэг ашигладаг.
Цэцэрлэг аж ахуйн нийгэм	НТӨ 4000 он тэртээ үүсэж Ази, Европ даяар тархсан	Ураг төрлийн холбоог халж олон төрлийн бүлгээс тогтох нийгэм	Энгийн хөдөлмөрийн багаж зэвсэг ашиглан тариалан эрхэлдэг
Газар тариалангийн нийгэм	Анх эртний Египетэд үүссэн бөгөөд түүхэнд хамгийн өргөн тархсан	Мал амьтныг ажиллах хүч болгон хэрэглэдэг тул нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй	Төр үүсэж, бичиг үсэг хэрэглэх болж, мөнгөн гүйлгээ ашиглах болсон.
Аж үйлдвэржсэн нийгэм	Их Британи дахь аж үйлдвэржилтийн нөлөөгөөр XVIII зууны сүүлчээр үүссэн	Амьтны булчингийн хүчийг халсан	Төрийн удирдлага нь бюрократ байгууллагын тогтолцоонд суурилсан

- A. Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 2-р багана
Газар тариалангийн нийгмийн 2-р багана
- C. Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 3-р багана
Аж үйлдвэржсэн нийгмийн 2-р багана
- E. Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 2-р багана
Газар тариалангийн нийгмийн 3-р багана

- B. Ан агнуурын нийгмийн 1-р багана
Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 3-р багана
- D. Газар тариалангийн нийгмийн 3-р багана
Цэцэрлэг аж ахуйн нийгмийн 3-р багана



9. Т.Билтоны тодорхойлсон “Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм”-ийн шинжүүдэд хамаарахыг олоорой. /2 оноо/

Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм	1	Хувийн хүсэл зориг гэхээсээ нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэн хувь хүн амьдардаг.
	2	Аж үйлдвэр эдийн засгийн гол талбар байна. Мөн шинжлэх ухаан тэргүүлэх үүрэгтэй байна.
	3	Хүний амьдралын үйл ажиллагааны гол талбар нь өрх гэр, гэр бүлийн хүрээ байна.
	4	Олон нийтийн байгууллагын хүрээнд олон янзын үүрэг хүлээж, олон талт харилцаа бүхий байна.
	5	Уламжлалт төрийн бүтэцтэй бөгөөд шашны болон домгийн итгэл үнэмшлийн тогтолцоотой.

- A. 1, 3 B. 4, 5 C. 2, 3 D. 2, 5 E. 2, 4

10. “Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэл юм” гэж дараах эрдэмтдийн аль нь үзсэн бэ? /1 оноо/

- A. Э.Кассирер B. Э.Тайлор C. А.Гидденс D. Р.Бенедикт E. Э.Фромм

Тохиолдлыг уншаад 11-13 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Бэк-Хён, Чан-Ёол, Ха-Кун, Ин-Су, Кижэ, Минжүн нар солонгос улсаас монгол улсыг зорин аялахаар иржээ. Энэхүү аялал нь зүгээр ч нэг аялал биш харин монгол улсын соёл, түүний үүсэл хөгжил болон соёлын үйлдвэрлэлийн тухай судлахаар ирсэн соёл судлаачид юм. Мэдээж Бэк-Хён, Чан-Ёол, Ха-Кун, Ин-Су, Кижэ, Минжүн нар монгол улсаар аялахдаа монгол улсын соёлын тухай мэдээлэл цуглуулж, судалгаа хийх тус тусын чиг үүрэгтэй ирсэн билээ. Тухайлбал:

- Бэк-Хён бол монгол хүмүүсийн зан төлөв, зан чанар болон шашны тухай,
- Чан-Ёол бол олон улсын соёл, барууны соёл, монголын соёлын тухай,
- Ха-Кун бол монголын социализмын үеийн соёлын тухай,
- Ин-Су бол монголын соёлын эртний, дундад зуун, орчин үеийн соёлын тухай,
- Кижэ бол монголын соёлын статик, динамик үзэгдлийн тухай,
- Минжүн бол монголын оюуны болон биет соёлын тухай тус тус судлахаар болжээ.

11. Солонгосын соёл судлаачдын тус бүрийн чиг үүрэг нь соёлын ямар шалгуурыг илэрхийлж байгааг зөв харгалзуулна уу? /1 оноо/

a) Соёлын нийгмийн хэв маягийн тухай b) Соёлын бүтээгч, хэрэглэгчийн тухай c) Соёлын суурь үнэлэмжүүдийн тухай d) Хүмүүсийн сонголт хийх боломжийн тухай	1	Судлаач Бэк-Хён
	2	Судлаач Чан-Ёол
	3	Судлаач Ха-Кун
	4	Судлаач Ин-Су
	5	Судлаач Кижэ
	6	Судлаач Минжүн

- A. a4b2c1d3 B. a4b5c1d6 C. a2b5c1d3 D. a2b6c1d4 E. a4b1c6d3

12. Дээрх тохиолдолд харуулж буй дүрслэлийг аль нь бүрэн илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Монголын соёлын ангилал болон судалгаа хийж байгаа аялагчдын тухай
B. Соёлын үйлдвэрлэл болон соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрүүдийн тухай
C. Соёлын аялал жуулчлал болон соёлын эрх чөлөөний суурь зарчмын тухай
D. Соёлын үйлдвэрлэл, аялал жуулчлал, соёлын ангилал, шалгуурын тухай
E. Соёлын үйлдвэрлэл, соёлын орон зай, эрх чөлөөний суурь зарчмын тухай



13. Дээрх тохиолдолд соёлын үйлдвэрлэл болон аялал жуулчлал нь юунд тулгуурлан хөгжиж байгааг тодорхойлно уу? /1 оноо/

- A. Монгол улсын соёлын аялал жуулчлалд баримталдаг зарчим болон соёлын аялал жуулчлалын төрөлд түшиглэн хөгжиж байна.
- B. Соёлын үйлдвэрлэл болон аялал жуулчлалын ач холбогдолд түшиглэн хөгжиж байгааг харуулж байна.
- C. Монгол улсын үүсэл хөгжил, соёлын үйлдвэрлэл болон судлаачдын эрэлт хэрэгцээнд түшиглэн хөгжиж байна.
- D. Монгол улсын 2015 онд батлагдсан “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрт түшиглэн хөгжиж байна.
- E. Соёлын даяаршил болон соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрт тулгуурлан түшиглэн хөгжиж байна.

14. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /2 оноо/


Хүснэгт дэх жишээг ажиглаад соёлын харилцан үйлчлэлийн аль хэлбэр дутуу байгааг өгөгдсөн жишээнүүдээс сонгоорой.

Соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрүүд	Монгол-Японы соёлын харилцааг дэмжих “Альянс” нийгэмлэгээс зохион байгуулсан “Япон улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн концерт”
	Нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан, өмнөх соёлоосоо илүүд үзэх үр дүн юм.
	

- А. Тулга 85 настай бөгөөд түүний аав нь халх, ээж нь буриад хүн байсан. Тулга халх болон буриад гэр бүлийн уламжлал, ёс заншлыг мөн чанарыг ойлгосон нэгэн бөгөөд тэрхүү соёлоо үр хүүхдүүддээ зааж сургаж ирсэн.
- В. Дорж Сүхбаатар аймгийн Дарьганга сумын өндөрлөг тэгш газарт 200 орчим унтарсан галт уул байдгийн тухай мэдээлэл гадаад, дотоодын аялагчдад хүргэж, соёлын үнэт зүйлсээ хамгаалж ирсэн.
- С. Ассир, Вавилон нь зэрэгцэн оршиж байсан ба оршин буй цаг хугацаандаа аль нэг улс нь хүчирхэг болох үедээ нөгөө улсаа эрхшээлдээ оруулдаг байв.
- Д. Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд “Монгол-Японы соёлын өвийн форум” зохион байгуулагдсан.
- Е. Нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан, өмнөх соёлоосоо илүүд үзэх үр дүн юм.

15. Дараах тохиолдолыг уншаад соёлын цочирдлын “Харь соёлд дасан зохицох үе шат”-ын аль үе шат дээр явж буйг тодорхойлоорой. /2 оноо/


График №1 /Харь соёлд дасан зохицох үе шат/



Тохиолдол

Зул Хятад улсад суралцахаар ирсэндээ маш их баяртай байлаа. Тэр ирсэн хотынхоо шинэ соёлд дасаж оюутан ангийнхаа хүүхдүүдтэй дотнын найзууд больё гэсэн бодолтой байсан ч эргэн тойрныхоо хүүхдүүдтэй харилцаа тогтоож чадахгүй байсан.

- A. A-ye шат B. C-ye шат C. F-ye шат D. B-ye шат E. E-ye шат



16. “Дэлхийн бүх улс орнууд он солигдох мөчийг өөрийн үндэстний зан үйл, итгэл үнэмшил, ёс заншлын онцлогоор угтан хуучин оноо үдэж, шинэ оноо угтдаг” гэсэн нь соёлын аль ойлголтод хамаарах вэ? /1 оноо/

A. Соёлын релятивизм

B. Түгээмэл шинж

C. Сонгодог соёл

D. Нэгдмэл шинж

E. Соёлын этноцентризм

17. Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадварыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

A. Соёлын дархлаа

B. Соёлын адилсал

C. Соёлын эрх чөлөө

D. Соёлын даяаршил

E. Соёлын үйлдвэрлэл

18. Логик хэмээх нэр томъёоны утга санааг аль нь зөв илэрхийлж байна вэ? /1 оноо/

A. Ямар нэгэн үзэгдэл, үйл явцын дараалал, харилцаа, холбоог илэрхийлнэ.

B. Логикийг хүний оюун ухаан, сэтгэлгээний чадвартай холбон хэрэглэдэггүй

C. Бодол, эргэцүүллийн эмх цэгц, нотолгоог нь гол шалгуур болгон авч үздэггүй

D. Зөв сэтгэхүйн хууль, дүрмүүдийн тухай шинжлэх ухаан биш

E. Үндэслэгээ, нотолгоо, няцаалтыг гол шалгуур болгон авч үздэггүй

19. Ойлголтын тухай өгөдлүүдийн аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой.

/1 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Судлагдаж буй юмс үзэгдлийн онцлох гол шинжид нь хамаардаггүй сэтгэлгээ юм.	Уг ойлголтоор сэтгэгдэж байгаа юмс үзэгдлийн ангийг ойлголтын агуулга гэнэ.
2-р хэсэг	Бүх ойлголт агуулга, бас багтаамжтай байна.	Сэтгэж танин мэдэх үйл явц нь ойлголт, бодомж, оюун дүгнэлтийн хэлбэрээр явагддаг

A. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

B. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б


C. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А

D. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б

E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

20. “Бүх квадрат бол дөрвөн тал нь тэнцүү тэгш өнцөгт мөн” гэсэн бодомжийг аль бүдүүвч нь зөв илэрхийлж байна вэ? /1 оноо/

Жич: W – квадрат, Q – дөрвөн тал нь тэнцүү тэгш өнцөгт



21. Инфляцийн бууруулах төрөөс авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа аль нь вэ? /1 оноо/

A. Бараа үйлчилгээний эрэлт муудна

B. Өндөр татвар хураах сонирхол бий болно

C. Бүтээгдэхүүний үнэ өснө


D. Үйлдвэрлэлийн өсөлтийг хангах

E. Эдийн засгийн дотоод тэнцвэрийг алдагдуулна



22. Чөлөөт эдийн засгийн тогтолцоонд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
- Үндсэн шинж нь хувийн өмч байдаг.
 - Хоёрдогч шинж нь ашгийн хойноос хөөцөлддөг.
 - Ихэнх материал нөөц баялаг нь нийтийн болон улсын өмчид байдаг.
 - Үйлдвэрлэлийн хэрэгсэл нь хувь хүмүүсийн эзэмшилд байдаг.
 - Төрөөс эдийн засгийн үйл явц дахь оролцоо маш бага байдаг

23. Дараах графикийг ажиглаад даалгаврыг гүйцэтгээрэй. /2 оноо/
- Дараах хөдөлмөрийн зах зээлийн графикийг анхааралтай ажиглаад асуултад хариулаарай.
- $W(\text{wage})$ -цалин (1000 нэгж буюу 1000000 төгрөг)
- $L(\text{Labor})$ -Хөдөлмөрийн тоо хэмжээ



Асуулт:

Ажиллах хүчний илүүдэл бий болсон цалингийн түвшин, эрэлт, нийлүүлэлтийн хөдөлмөрийн тоо хэмжээг олоорой.

Цалин	Хөдөлмөрийн нийлүүлэлт буюу ажил хайгчийн тоо хэмжээ	Хөдөлмөрийн эрэлт буюу ажиллах хүчний тоо хэмжээ
.....?	?	?

- Цалин-3300; ажил хайгчийн тоо хэмжээ-300; ажиллах хүчний тоо хэмжээ-400
 - Цалин-3300; ажил хайгчийн тоо хэмжээ-400; ажиллах хүчний тоо хэмжээ-300
 - Цалин-3300; ажил хайгчийн тоо хэмжээ-250; ажиллах хүчний тоо хэмжээ-450
 - Цалин-3300; ажил хайгчийн тоо хэмжээ-450; ажиллах хүчний тоо хэмжээ-300
 - Цалин-3300; ажил хайгчийн тоо хэмжээ-450; ажиллах хүчний тоо хэмжээ-250
24. Дараах ойлголтуудаас аль нь татвар хураалтын ил тод байх зарчмыг илэрхийлж байна вэ? /1 оноо/
- Бүх нийтээр төлдөг, татвар нь хүмүүсийн орлоготой шууд хамааралтай
 - Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулж буй хүмүүс, ААН-ээс авах татвар
 - Бүх хүн хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж
 - Татварын хэмжээ болон татвар хураах аргыг урьдчилан мэдэгдсэн байх
 - Завсрын ямар нэгэн шат дамжлага дамждаг(нэмэгдсэн өртгийн алба татвар)
25. Хөрөнгийн зах зээлийн өөрчлөлт хөдөлгөөнийг хоёр амьтны ерөнхий шинж чанартай нь адилтгадаг. Тэгвэл зах зээл дэх хөрөнгө оруулагч нар хувьцаагаа зарах нь ихсэж нийлүүлэлтийг нэмэгдүүлснээр хувьцааны үнэ буурахыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
- Bear market
 - Bull market
 - Tiger market
 - Wolf market
 - Dragon market



26. ДНБ-ий өсөлтийг онуудаар харуулж буй хүснэгтийг ажиглаад “Абсолют цэвэр өсөлт” болон “Өсөлтийн хурд”-ыг тооцоолоорой. /2 оноо/

Дараах томъёонуудаас сонгон бодолтыг хийгээрэй.

Y_n -Тухайн оны үзүүлэлт;

Y_{n-1} -Өмнөх оны үзүүлэлт

$$Y_n - Y_{n-1}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\%;$$

$$\frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\% - 100\%;$$

Он	Үсгэн тэмдэглэгээ	ДНБ, тэрбум төгрөг	Абсолют цэвэр өсөлт	Өсөлтийн хурд /дахиаар/
2023	Y_{2023}	29,600,0	-	-
2024	Y_{2024}	37,800,0	a.....	b.....

A. a-8,200,0; b-127.7

B. a-8,200,0; b-27.7

C. a-27.7; b-8,200,0

D. a-8,200,0; b-1.277

E. a-1.277; b-8,200,0

Хүснэгтийг ажиглаад 27-28 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Монгол улсын гадаад худалдаа, сая ам.долл.				
№	Үзүүлэлт	2022	2023	2024
1	Нийт экспорт	5928.3	4845.9	5944.8
2	Нийт импорт	6586.5	5128.3	5159.7
3	Гадаад худалдааны тэнцэл	?	?	?
4	Ашиг/ алдагдал	?	?	?

27. Дээрх гурван оны гадаад худалдааны тэнцлийг зөв тодорхойлоорой. /1 оноо/

A. 2022 онд /+658.2/, 2023 онд /+282.4/, 2024 онд /-785.1/

B. 2022 онд /-658.2/, 2023 онд /-282.4/, 2024 онд /+785.1/

C. 2022 онд /-658.2/, 2023 онд /+282.4/, 2024 онд /-785.1/

D. 2022 онд /+12,514.8/, 2023 онд /-9,974.2/, 2024 онд /-11,104.5/

E. 2022 онд /-12,514.8/, 2023 онд /+9,974.2/, 2024 онд /+11,104.5/

28. Дээрх гурван оны гадаад худалдааны ашиг болон алдагдлыг зөв тодорхойлоорой. /2оноо/

A. 2022 онд /алдагдал/, 2023 онд /алдагдал/, 2024 онд /ашиг/

B. 2022 онд /ашиг/, 2023 онд /алдагдал/, 2024 онд /алдагдал/

C. 2022 онд /алдагдал/, 2023 онд /ашиг/, 2024 онд /ашиг/

D. 2022 онд /ашиг/, 2023 онд /ашиг/, 2024 онд /алдагдал/

E. 2022 онд /ашиг/, 2023 онд /алдагдал/, 2024 онд /ашиг/

29. “Улс төр бол эрх мэдэлд хүрэх, эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашиглан албадлагын арга хэрэгслийн цогц юм” гэж үздэг нь хэний үзэл баримтлал вэ? /1 оноо/

A. Б.Макиавелли

B. Р.Даль

C. Ж.Локк

D. Ш.Монтескье

E. Д.Истон

30. 1990 оноос өмнөх төрийн бодлогод аль нь хамаарах вэ? /1 оноо/

A. Бизнесийн тодорхой төлөвлөгөөгөөр нийгмээ болон өөрийгөө хөгжүүлэх

B. Олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрч, олон намын тогтолцоог чухалчлах

C. Сонгох, сонгогдох ардчилсан зарчмыг улс төрийн кампани болгож төлөвлөх

D. Хувийн өмчтэй байхыг зөвшөөрч, түүнийхээ үр шимээр амьдрах

E. Улс түмний харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэх



31. Монгол улс түүхэндээ хэдээс хэдэн оны хооронд зөвхөн “ангийн” сонгуультай байсан бэ?
/1 оноо/

- A. 1924-1990 он B. 1924-1951 он C. 1924-1992 он
D. 1924-1960 он E. 1924-1940 он

32. Дараах тохиолдлыг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй. /2 оноо/

Сонгуулийн мэдээ

2020 оны сонгуульд 800,000₮ болон түүнээс доош цалинтай иргэдийн 25%, 800,000₮-1,300,000₮ цалинтай иргэдийн 48%, 1,300,000₮-2,000,000₮ цалинтай иргэдийн 52%, 2,000,000₮-2,700,000₮ цалинтай иргэдийн 74%, 2,700,000₮-3,500,000₮ цалинтай иргэдийн 86%, 3,500,000₮ болон түүнээс дээш цалинтай иргэдийн 98% нь саналаа өгчээ.

Жич: Зохиомол тохиолдол тул тоон үзүүлэлтүүд нь тодорхой бүлгүүдийг илтгээгүй

Асуулт: Сонгогчдын оролцооны хандлагад ямар бодит тайлбарууд байж болох вэ?

- A. Бага цалинтай хүмүүс нь сонгууль болон улс төрийн тухай мэдээлэл авч чаддаггүй аль эсвэл мэдээлэлгүйгээсээ болоод ирц хангалтгүй байна.
B. Бүх иргэдэд улс төрийн тухай ойлголт дутмаг байгаа тул сонгуулийн оролцооны ирц хангалттай байдаг.
C. Өндөр цалинтай хүмүүс сонгууль болон улс төрийн тухай мэдээлэл бүрэн авч чаддаг болон мэддэг тул саналаа тэр бүр өгөөд байдаггүй.
D. Дундаж цалинтай хүмүүс ажил мэргэжил, албан тушаал, карьераа өөрчлөхийн тулд ихэвчлэн санал хураалтад идэвхтэй оролцдог.
E. Бага цалинтай хүмүүс ажил мэргэжил, албан тушаал, карьераа өөрчлөхийн тулд ихэвчлэн санал хураалтад идэвхтэй оролцдог.

33. Д.Истоны улс төрийн системийн ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.
/ 2 оноо/

a) Шийдвэр b) Бодит дэмжлэг c) Оролцооны дэмжлэг	1	Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид орших нийгмийн хүрээ буюу хүмүүсийн нэгдэл
	2	Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль дүрмийг дагаж мөрдөх
	3	Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх
	4	Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт

- A. a4b3c2 B. a4b2c3 C. a1b2c3 D. a1b3c2 E. a4b1c2

34. Сонирхлын бүлгийн чиг үүргийн тухай ойлголтуудыг аль хэсгийн, ямар дараалал илэрхийлж байна вэ? /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай бүлэг	Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид орших нийгмийн хүрээ
2-р хэсэг	Бүлгийн сонирхлыг нэг үзүүрт чиглүүлэх буюу нэгтгэхэд чиглэдэг.	Нийгэм дэх олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах.

- A. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
E. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А



35. Монгол улс 1990 оноос өмнө намын ямар тогтолцоотой байсан бэ? /1 оноо/
 А. Олон намын тогтолцоо В. Хоёр намын тогтолоо С. Нэг намын тогтолцоо
 D. Аядуу плюрал тогтолцоо E. Ноёрхогч намын тогтолцоо

36. Улс төрийн засаглалын үндсэн хэмжигдэхүүний тухай хүснэгтийг ажиглаад дутууг дараах өгөгдлүүдээс сонгоорой. /2 оноо/

Үндсэн хэмжигдэхүүн	Тодорхой газар нутагт засаглалын үйл ажиллагаа үр ашигтай явагдана.
	Тухайн засаглалын оршин тогтнох хугацаа
	Хичнээн тооны засаглал хэн нэгний гарт төвлөрч байгааг илэрхийлдэг.
	

- A. Нийгмийн институт болон удирдлагын тусламжтайгаар субъект өөрийн ноёрхлоо тогтоох
 B. Засаглалын субъект зорилгоо хэрэгжүүлэхийн тулд объектод үзүүлж буй арга хэрэгслийг хэлнэ.
 C. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль дүрмийн дагуу ардчилсан хэм хэмжээнд тулгуурладаг.
 D. Нийгэм дэх улс төрийн харилцаа засаглалыг хэрэгжүүлэх арга хэлбэр, төр нийгмийн хоорондын харилцаа
 E. Ямар нэгэн засгийн нөлөө, ач холбогдол, цар хүрээ, хэм хэмжээг тодорхойлох үзүүлэлт
37. Алмонд, Верба нарын боловсруулсан улс төрийн соёлын хэв маягууд аль нь вэ? /2 оноо/
 А. Дадал заншлын; Хууль зүйн В. Конвенционал; Конвенционал бус
 C. Оролцогчид; Албатууд; Овгийнхон D. Хууль ёс; Хууль ёсны бус
 E. Ортодоксал оролцоо; Ортодоксал бус оролцоо; Улс төрийн гэмт хэрэг
38. “Common Law”, “Шүүгчийн эрх зүй” гэх зэргээр нэрлэж заншсан эрх зүйн бүл аль вэ? /1оноо/
 А. Англи-Америкийн эрх зүйн бүл В. Ром-Германы буюу эх газрын эрх зүйн бүл
 C. Заншлын эрх зүйн бүл D. Холимог болон хосолмол эрх зүйн бүл
 E. Шашны эрх зүйн бүл
39. Эрх зүйн хэм хэмжээний дотоод хэлбэр аль нь вэ? /1 оноо/
 А. Гипотез; Диспозици; Санкц
 B. Хэм хэмжээний заалт; Хэм хэмжээний институт; Эрх зүйн бүрдэл
 C. Албан хэм хэмжээ; Албан бус хэм хэмжээ; Хэм хэмжээ
 D. Материаллаг эрх зүй; Процессын эрх зүй; Шатлалын онол
 E. Эрх зүйн харилцааны объект; Хууль зүйн факт; Эрх зүйн харилцааны агуулга
40. 2025 оны 5-р сарын 20-нд болсон хэргийн тухай иргэн С 2025 оны 6-р сарын 2-ны өдөр гомдол захиргааны байгууллагад гаргасан нь хугацаа хэтэрсэнд тооцогдох уу? /2 оноо/
 А. 5-р сарын 20-ны өдөр болсон хэргийг 6-р сарын 2-нд захиргааны байгууллагад гомдол гаргасан тул хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлтэй.
 B. Эрх нь зөрчигдсөнөөс хойш 14 хоногийн дотор гомдол гаргах ёстой байдаг тул захиргааны байгууллага гаргасан гомдлыг хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлгүй.
 C. 5-р сарын 20-ны өдөр болсон хэргийг 6-р сарын 2-нд захиргааны байгууллагад иргэн С хэргийн гэрчтэй хамт гомдол гаргаагүй тул хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлтэй.
 D. 5-р сарын 20-ны өдөр болсон хэргийг 6-р сарын 2-нд захиргааны байгууллагад гуравдагч этгээдтэй хамт гомдол гаргаагүй тул хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлтэй.
 E. Эрх нь зөрчигдсөнөөс хойш 30 хоногийн дотор захиргааны байгууллагад гомдол гаргасан тул хугацаа хэтэрсэнд тооцох үндэслэлгүй.



41. Өмчлөх эрх үүсэх гэрээнд заасан үндэслэл аль вэ?

/1 оноо/

- A. Эд хөрөнгийг хувьчлан авах В. Эзэнгүй эд юмс олж авах С. Эд хөрөнгийг засах
D. Арилжааны гэрээ E. Шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгөтэй болох

42-45 дугаар даалгаврыг доорх тохиолдлыг уншиж гүйцэтгээрэй.

АЖЛЫН БАЙР

Иргэн А 2023/08/28-нд нэгэн сургуульд багшаар ажилд орохоор ажил олгогч Д-тэй уулзаж ярилцлагад орсон. Харин ажил олгогч Д нь А-г ярилцлагад орсны дараа ажил даалгаж өгсөн байна. Ажилч олгогч Д болон А хоёр 2023/09/01-ны өдөр хөдөлмөрийн гэрээгээ байгуулж гарын үсэг зуралцсан. 2025/01/20 өдрөөс ажил олгогч Д нь А-д ажлын байрны дарамт удаа дараа үзүүлсэн. А нь жирэмсэн байсан тул энэхүү ажлын байрны дарамтаас болж бие нь өвдсөн. Тиймээс 2025/02/07-ны өдөр сургуулийнхаа ёс зүйн хороонд хандсан.

42. Ажил олгогч Д нь ажилтан А-г ярилцлагад орсны дараа ажил даалгаж болох уу? /2 оноо/

- A. Ажил олгогч Д нь үндсэн хуулийн 16-р зүйлийг үндэслэн ажилтан А-д ажил даалгаж болно.
B. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй бол ажилтанаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй.
C. Иргэн А нь багшаар ажилд орсон тул хөдөлмөрийн гэрээ байгуулах шаардлагагүй тул, ажил үүргээ гүйцэтгэж болно.
D. Ажил олгогч Д нь хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийг үндэслэн ажилтан А-д ажил даалгаж болно.
E. Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ч гэсэн ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болно.

43. Ажил олгогч Д нь сахилгын зөрчил гаргасан бол түүнд хэдэн сарын дотор шийтгэл ноогдуулах ёстой вэ? /2 оноо/

- A. Зөрчил гарснаас хойш 9 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 4 сарын дотор
B. Зөрчил гарснаас хойш 7 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 2 сарын дотор
C. Зөрчил гарснаас хойш 8 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 3 сарын дотор
D. Зөрчил гарснаас хойш 6 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын дотор
E. Зөрчил гарснаас хойш 10 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 5 сарын дотор

44. Иргэн А нь сургуулийн ёс зүйн хороонд хандахдаа доорх хэлбэрээс алийг нь сонгох вэ?

/1оноо/

- A. Захиргааны акт В. Нэхэмжлэл С. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр
D. Өргөдөл E. Гомдол

45. Иргэн А жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг цалингийн хэдэн хувиар тооцон нийгмийн даатгалын сангаас авах ёстой вэ? /1 оноо/

- A. 12 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.
B. 16 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.
C. 17 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.
D. 17 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.
E. 12 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.



46. Даатгуулагч Сувд нь 55 настай, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 29 жил төлсөн бол тэтгэврийн нэмэгдэл нь хэдэн хувиар нэмэгдэхийг тооцоолно уу. /2 оноо/
 A. 29% B. 9% C. 14.5% D. 13.5% E. 43.5%
47. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. Тэгвэл өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээ хэд болохыг тооцоорой. /2 оноо/
 A. 330,000 төгрөг B. 560,000 төгрөг C. 495,000 төгрөг
 D. 660,000 төгрөг E. 462,000 төгрөг
48. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой.
 Олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэрийг гэнэ. /1 оноо/
 A. Диспозитив B. Де-юре C. Императив D. Де-факто E. Дипломат
49. Олон улсын харилцааны улс бус оролцогчдод аль нь хамаарах вэ? /1 оноо/
 A. Бага улс B. НҮБ C. Их гүрэн D. Дунд улс E. Бүрэн эрхт улс
50. Нэгдсэн Үндэсний Байгууллагыг бий болгох санаа хэзээнээс эхэлсэн бэ? /1 оноо/
 A. 1939-1945 оны үед болсон дэлхийн II дайны үеийн хүнд бэрх өдрүүдэд
 B. Сирусийн бортого бий болсон үед /боолуудыг чөлөөлсөн үеэс/
 C. Дэлхийн нэгдүгээр дайны дараа хүний эрх, эрх чөлөөг хангаж дээдлэхийн тулд
 D. “Магна Харта” хэмээх тунхаг бичиг баталгаажуулснаар
 E. Хүйтэн дайны төгсгөл үеэс
51. Бүс нутгийн түвшний байгууллагад аль нь хамаарах вэ? /1 оноо/
 A. Исламын улсуудын чуулга уулзалт B. ОУ-ын гаалийн шүүх C. НҮБ
 D. ШХАБ E. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
52. Дараах өгөгдлөөс хоёр хөрштэйгээ харилцах зарчмуудыг олоорой. /2 оноо/
 Өгөгдөл: /1-сайн хөршийн, 2-тэнцвэртэй найрсаг, 3-стратегийн түншлэлийн, 4-хамтын ажиллагааны, 5-олон тулгуурт, 6-улс төрийн/
 A. 1,2,3,5,6 B. 1,2,3,4,6 C. 2,3,4,5,6 D. 1,2,4,5,6 E. 1,2,3,4,5
53. Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал нь Монгол улсын ОУ-ын хамтын нийгэмлэг дэх оролцооны аль зарчимд хамаарах вэ? /1 оноо/
 A. Прагматик байх B. Олон тулгуурт байх C. Тэнцвэртэй байх
 D. Үндэсний эрх ашигт нийцсэн байх E. Найрсаг байх
54. Дараах өгөгдлийг ажиглаад 2018 оны байдлаар Монгол улстай “стратегийн түншлэлтэй” улсуудыг олоорой. /2 оноо/
 Өгөгдөл: /1-ОХУ, 2-Япон, 3-Энэтхэг, 4-БНСУ, 5-Герман, 6-Канад/
 A. 1,3,6 B. 1,2,3 C. 2,3,5 D. 2,5,6 E. 1,3,5



55. Монгол улсын “Гуравдагч хөрш” орнуудын хамтын үйл ажиллагаа зөв харгалзуулна уу.

/2 оноо/

a) АНУ b) Япон c) БНСУ	1	1990 онд Монгол улстай дипломат харилцаа тогтоож, 1991 онд тус улсад Монгол улс элчин сайдын яамаа нээжээ.
	2	Монголын 350 гаруй залуус Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагджээ.
	3	Инженер технологийн дээд боловсрол төслийн хүрээнд Коосэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

A. a3b1c2

B. a2b1c3

C. a1b3c2

D. a3b2c1

E. a2b3c1

56. Жозеф Самуэль Най, Роберт Коэхэнтэй хамтран 1977 онд олон улсын харилцааны неолиберал онолын чиглэлээр “Хүч чадавх ба харилцан хамаарал” гэсэн бүтээлээ туурвисан. Энэхүү бүтээлд хамаарах үзэл санааг ялгаарай.

/2 оноо/

1. Хатуу, зөөлөн хүчний ялгааг тайлбарласан
2. Соёлын дипломат харилцааг тайлбарласан
3. Зөөлөн хүчний онолыг анх удаа дэвшүүлсэн
4. Гуравдагч хөршийн бодлогыг дэвшүүлсэн

A. 3, 4

B. 1, 2

C. 2, 4

D. 1, 3

E. 2, 3

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/5 оноо/

a) Меркантилизм b) Физиократизм c) Сонгодог эдийн засгийн ухаан d) Шинэ сонгодог онол e) Кейнсизм	1	Ашиг хонжоо олох гэсэн үйл ажиллагаа нь бодит хуулиар зохицуулагддаг ба “үл үзэгдэгч гарын зохицуулалт” гэж нэрлэдэг.
	2	Гол онцлог нь улс орны баялаг гүйлгээний хүрээнд бий болдог бөгөөд үндэсний баялаг нь мөнгө юм гэж үздэг
	3	Ажилчны бүтээсэн хөлсний хөдөлмөрийг капиталист мөлжих замаар ашгийг бүтээдэг, ингэж олсон ашгийг “нэмүү өртөг” гэдэг.
	4	Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо хамаарал байхгүй гэж үздэг.
	5	Төрийн зохицуулалтаар эдийн засгийн үр өгөөжтэй хөгжлийг хангаж болно.
	6	Улс орны баялаг зөвхөн ХАА, газар тариаланд л бүтээгддэг, тариаланчдын хөдөлмөр л бүтээлч хөдөлмөр гэж үздэг.



2.2. Намын үзэл баримтлалыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/5 оноо/

а) Зүүний нам b) Барууны нам c) Кокус нам d) Боловсон хүчний нам e) Олон түмний нам	1	Намын хэргийг намын элит болон лидерүүд нь хариуцан хэрэгжүүлдэг.
	2	Хатуу гишүүнчлэлтэй, сонгуулийн бус үеэр ч үйл ажиллагаа явуулдаг.
	3	Хатуу гишүүнчлэлгүй, сонгуулийн үеэр л идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг
	4	Төрийн нийгмийн бодлогыг хязгаарлахыг эрмэлздэг. Бизнес эрхлэгч, хувийн өмчтөн, дунд ангийнхныг дэмждэг.
	5	Төрийн нийгмийн бодлогыг явуулах эрмэлзэлтэй. Доод хэсгийнхэн буюу ядуу хэсгийг ч дэмждэг.

2.3. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/5 оноо/

а) Тунхаглал b) Конвенц c) Протокол d) Гэрээ e) Хүсэлт	1	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ
	2	Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой анхан шатны шүүхээр дамжуулан эрх зөрчигчид тавьж буй шаардлага.
	3	Хуульчлан дагаж мөрдөх албагүй зөвлөмж, уриалгын шинжтэй баримт бичиг
	4	Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичиг
	5	Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт
	6	Хоёр ба түүнээс дээш тооны этгээдүүд үр дагаврыг бий болгох байдлаар харилцан тохиролцож хийсэн бичвэр

2.4. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/5 оноо/

а) Неолиберал онол	1	ОУХ-ны бүрэн эрхт субъектүүд нь бүрэн эрхт улс, үндэстэн дамнасан порпациуд, ЗГ-ын бус байгууллагууд байдаг
b) Неореалист онол	2	ОУХ-ны үндсэн тоглогчид нь бүрэн эрхт улс дангаар биш түүнээс гадна ОУБ, үндэсний болон бусад нийгэмлэг, хувь хүмүүс байж болно
c) Неомарксист онол	3	ОУХ-ны үндсэн тоглогчид нь нийгмийн ангиуд байна.
d) Либерал онол	4	ОУХ-ны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, эвсэл байна.
e) Реалист онол	5	ОУХ-ны тоглогчид нь зөвхөн үндэсний бүрэн эрхт улсууд байдаг
	6	ОУХ нь нийгмийн тодорхой анги бүлэглэлүүдийн харилцааны үр дүн юм.

